



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2014 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 04.

Улаанбаатар хот

**Монгол орны ойн цэвэрлэгээний
талаар авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2013 оны 19 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгээс гаргасан дүгнэлт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

НЭГ.Монгол орны ойг цэвэрлэх талаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд /С.Оюун/-д үүрэг болгосугай. Үүнд:

1/ойн цэвэрлэгээ хийх шаардлагатай талбайн нарийвчилсан судалгаа хийж, түүнд тулгуурлан ойн цэвэрлэгээг экосистемд сөрөг нөлөөлөлгүйгээр ойн тогтвортой менежментийг ханган зохион байгуулж, ойжуулалт болон нөхөн сэргээх ажлыг төлөвлөн, хэрэгжүүлэх;

2/ойн цэвэрлэгээ хийхэд ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн болон төрийн бус байгууллагуудыг хамруулан төр, хувийн хэвшлийн оролцоог хангаж, шинээр ажлын байр бий болгох, шаардлагатай тохиолдолд ажилчдад мэргэжлийн ур чадвар олгох, дадлагажуулах сургалт зохион байгуулах;

3/ойн цэвэрлэгээнээс гарсан мод, модон бүтээгдэхүүн борлуулах, үртэс зоргодсоор шахмал түлш, барилгын материал үйлдвэрлэх санаачилгыг дэмжин зохион байгуулж, хэрэгжилтийг хангах талаар аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг, чиглэл өгч ажиллах;

4/ойн цэвэрлэгээ хийх газар нутгийн ойд замын хайгуул хийж, зураг, төсөв боловсруулах, ойн зам барьж байгуулах ажлын зардлыг жил бүрийн төсөвт тусгаж хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

5/мод, модон материалын зах зээлийн эрэлт хэрэгцээний тодорхой хэсгийг цэвэрлэгээнээс гарах бүтээгдэхүүнээр хангах замаар хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ авч ажиллах;

6/Монгол орны ойг цэвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор төсөл, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, мод орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа болон хаягдалгүй, ногоон технологи нэвтрүүлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжиж ажиллах.

ХОЁР.Энэ тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг холбогдох эх үүсвэрээс гаргаж дэмжлэг үзүүлэх, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллан, хэрэгжилтийн талаарх мэдээллийг 2014 оны намрын чуулганы хугацаанд Байнгын хороонд ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд /Н.Алтанхуяг/-д даалгасугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА



Г. БАЯРСАЙХАН

